



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



REDD+-ИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОХ СТРАТЕГИ/ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БОЛОМЖИТ ХУВИЛБАРУУД, ЗӨВЛӨМЖҮҮД

Хамрах хугацаа: 2016 оны 10-р сараас – 2018 оны 10-р сар

UN-REDD
PROGRAMME



Food and Agriculture
Organization of the
United Nations



UN
DP



UNEP

Empowering lives.
Resilient futures.

1.0 Монгол улс REDD+-ийн талаар цаашид ямар бодлого барьж байгаа бэ?

Монгол улс нь REDD+-ийн гишүүн орсон. REDD+ санаачилга нь анх үр дүнд суурилсан урамшуулал нэвтрүүлэх зорилгоор байгуулсан. Монгол улсад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ойн хомсдол, доройтол маш бага тул үр дүнд суурилсан урамшууллыг хүртэх магадлал багатай.

Гэхдээ REDD+-ийн стратегийг боловсруулах нь олон давуу талтай.

- Ойн менежментийг сайжруулах улс орны хүчин чармайлтыг нэгтгэж өгнө
- Тухайн улс орныг донор болон хувийн салбараас санхүүжилт авахад дэмжлэг үзүүлнэ
- Ойн хяналтын системийг боловсруулж, сайжруулдаг
- Өргөн хүрээнд салбар дундын талуудын оролцоог нэмэгдүүлнэ
- Монгол улсын REDD+-ийн стратеги нь уур амьсгалын өөрчлөлтийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Ойн талаар төрөөс баримтлах бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилтод хүрэх нэг хэрэгсэл юм.

2.0 Монгол улсын үзэл баримтлал

2.1 Үзэл баримтлал

Монгол улсын REDD+-ийн үзэл баримтлал нь ойг тогтвортой хөгжилтэй холбох, менежментийг сайжруулах замаар ойг хомсдол, доройтол хүргэж буй уур амьсгалын өөрчлөлт, дарамтыг тэсвэрлэх урт удаан хугацааны чадавхыг бий болгох юм.

Ойд нийгэм болон эдийн засгийн хөгжлийг бий болгохын тулд ойн тогтвортой менежментийн стратеги болон экосистемд суурилсан дасан зохицох үйл ажиллагаанд REDD+-ийн стратеги төвлөрөх шаардлагатай.

Стратеги нь REDD+-ийн стратеги / үйл ажиллагааны төлөвлөгөө гэхээсээ илүүтэйгээр Ойн болон уур амьсгалын өөрчлөлтийн стратеги гэж нэрлэвэл илүү тохиромжтой.

2.2 Үндэсний буюу бүс нутгийн

REDD+-ийн стратеги нь ихэнхдээ Үндэсний хэмжээнийх байдаг боловч бүс нутгийн хэмжээнд байж болно. Бүс нутгийн хүрээнд илүү төвлөрсөн үйл ажиллагаануудтай байдаг.

Үндэсний стратеги нь бореал болон заган ойг хамарна. Гэхдээ эхний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бореал ойд зориулж гаргах ба дараагийн тусдаа хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь заган ойнх байна.

Тэмдэглэл: Ойн суурь түвшнийг бореал ой дээр тодорхойлох ба заган ойн хувьд холбогдох мэдээлэл дутуу, бага судлагдсан, нүүрстөрөгчийн агууламж бага зэргээс үүдэн судалгааг өргөн хүрээнд хийхгүй.



3.0 НҮБУАӨСК-ийн дагуу REDD+-ийн гишүүн орнуудад ямар шаардлагууд тавьдаг вэ?

НҮБУАӨСК-ийн Варшавын гэрээний дагуу REDD+-ийн гишүүн орон үр дүнд тулгуурласан урамшуулал хүртэхийн тулд Үндэсний стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж батлах шаардлагатай.

НҮБУАӨСК нь улс орнуудад Үндэсний стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөөг дотоодын нөхцөл байдалд тохирсон загвараар боловсруулах боломжийн олгодог ба гэхдээ эдгээр баримт бичиг нь өөрөө конвенцээс заасан ерөнхий удирдамжийг тусгасан байх шаардлагатай.

Зарим улс орнууд (жишээ нь, Бразил, Бүгд Найрамдах Конго Улс, Индонез) нөхцөл байдалдаа тохируулан REDD+-ийн стратеги, зарим нь орнууд (жишээ нь, Эквадор) үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байдаг. Практик дээр өөр байж болох боловч стратегиасаа үйл ажиллагааны төлөвлөгөө нь илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан байдаг. Үндсэн баримт бичиг дээр (Үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө аль нь ч байж болно) нэмээд зарим улс орнууд хэрэгжүүлэх эхний хэдэн жилийг анхааран авч үзэж REDD+-ийн төлөвлөлтийн процессыг нэг болон хэд хэдэн дэлгэрэнгүй бичиг баримтын дагуу хэрэгжүүлэх нь ч бий. Үүнийг “Хөрөнгө оруулалтын Төлөвлөгөө” (жишээ нь Бүгд Найрамдах Конго Улс), “Хөрөнгө оруулалтын тогтолцоо” (жишээ нь Зааны Эргийн Улс), түүнчлэн “Үйл ажиллагааны төлөвлөгөө” (жишээ нь Бразил) гэж нэрлэх нь бий. Энэ төрлийн бичиг баримт нь улсыг бүхэлд нь хамарч болох эсвэл тодорхой нэг бүс нутаг дээр төвлөрч болно (жишээ нь Бразил). Бусад нь Үндэсний түвшинд хэд хэдэн салбарын төлөвлөгөөг боловсруулахаар хийгдсэн байдаг. (жишээ нь, Эквадор).

4.0 Монгол улсад өгөх зөвлөмж

3 хэсгээс бүтсэн үйл ажиллагааг Монголд хэрэгжүүлэхээр зөвлөмж өгсөн.

4.1 1-р хэсэг – REDD+-ийг одоо байгаа бодлогуудад тусгах, нэгтгэх

Ойн болон уур амьсгалын өөрчлөлтийн стратеги нь аль хэдийн дараах бодлогуудад тусгалаа олсон: Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Ойн талаар төрөөс баримтлах бодлого, түүний үйл ажиллагааны төлөвлөгөө, 2010-2015 Ойн салбарын Менежментийн төлөвлөгөө болон Уур амьсгалын Өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр.

Нэгтгэх боломжууд:

- Уур амьсгалын Өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр - 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үе шатанд байна
- Ойн талаар төрөөс баримтлах бодлогын Үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө 2017 оны 4-р сард батлагдсан.
- Ойн салбарын менежментийн төлөвлөгөө – 2016-2020 оны шинээр боловсруулж байгаа.

Асуулт : Одоогийн хэрэгжиж буй бодлогод нийцүүлж тусгах ямар боломжууд байна вэ?

4.2 2 хэсэг - Ерөнхий стратегийн баримт бичгүүд

Ой болон уур амьсгалын өөрчлөлтөд чиглэсэн өргөн хүрээтэй стратегийн бичиг баримт боловсруулах.

Стратегийн баримт бичгийн хувилбаруудыг доор үзүүлэв (5.0–г харна уу).

4.3 3 хэсэг - Хөрөнгө Оруулалтын Төлөвлөгөө

Одоо байгаа төсвийг тусгасан хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах.

- Энэ төлөвлөгөө нь Үндэсний хэмжээнд эсвэл бореал ой бүхий 3-4 үндсэн аймгуудыг хамруулж болно.
- 2 дахь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө өөр цаг хугацаанд заган ойг хамрах авч үзэж болно.

Зарим орнуудад хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг түүний тодорхой хэсгийг санхүүжүүлэх боломжтой Ногоон Уур Амьсгалын сангийн саналтай зэрэг боловсруулдаг. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь Ногоон Уур Амьсгалын сангийн дэмжлэгийг авснаар дараах боломжууд нээгдэнэ:

- Илүү өргөн хүрээтэй, тохиромжтой арга барилын нэг хэсэг
- Үндсэн гажуудал, цоорхой хаана байгааг тодорхойлж, оновчтой шийдлийг хаана, хэрхэн зохицуулахыг стратегитайгаар чиглүүлэх
- Хэдийгээр зарим бодлогын арга хэмжээнүүд нь өөр баримт бичигт тусгагдсан ч, бие даасан баримт бичгийг боловсруулж батлуулах үндсэн шалтгаан нь Ногоон Уур Амьсгалын сангийн дэмжлэгийг авах байсан гэж тайлбарлах.

5.0 Монголын нөхцөлд ямар төрлийн бичиг баримт тохиромжтой бэ?

Зарим орнууд бичиг баримтууд нь тухайн оронд мөрдөгддөг хуулийн бичиг баримттай үндсээрээ тохирч байх хэрэгтэй болдог учраас хязгаарлагдмал байдалд ордог. Монголд ямар төрлийн бичиг баримт боловсруулах шаардлагатай, тэдгээрийн сул тал болон хэрхэн шинэчилж болохыг бид үнэлгээ хийж тодруулах шаардлагатай байгаа.

REDD+-ийн бичиг баримтуудад тавигддаг хэд хэдэн зарчмуудыг доор тусгалаа:

- **Өндөр хэмжээний дэмжлэг**- Энэхүү баримт бичигт БОАЖЯ болон бусад оролцогч талуудын өндөр түвшний дэмжлэг шаардлагатай. Өөрөөр хэлбэл, энэ төрлийн баримт бичиг нь Сангийн Яам, Их Хурал болон бусад яамдаас дэмжлэг авахуйц хангалттай түвшнийх байх шаардлагатай.
- **Салбар дундын** - Энэ төрлийн баримт бичиг нь салбар дундынх байх шаардлагатай.
- **Агуулга** – Стратегийн баримт бичиг нь Ойн болон Уур амьсгалын стратегийн үе шатуудыг тусгасан байх, мөн дэлгэрэнгүй байх шаардлагатай. Зарим улс орнууд жишээ нь Мьянмар докторын судалгааны ажил шиг хэтэрхий урт бичиг баримт боловсруулсан байхад, Вьетнам REDD+-д бэлтгэх төлөвлөгөөг маягийн бодлогын баримт бичиг нь хэтэрхий товчоор боловсруулсан байдаг.
- **Давхардсан бодлого болон Бодлогын сул байдал** - Монголд одоо хэрэгжиж буй олон тооны бодлогын баримт бичгүүд бий. Бидний боловсруулах бодлого бусад бодлоготой давхцахгүй, өвөрмөц арга барилтай, бодит нөхцөл байдалд сайн хэрэгжих боломжтой эсэхийг анхаарч авч үзэх шаардлагатай. Яагаад гэвэл одоогийн хэрэгжиж буй ихэнх бодлого цаасан дээр л үлддэг.

6.0 Монгол улсын бодлого болон эрхзүйн орчин

Монгол улс 2015 онд бодлого, эрхзүйн орчноо боловсронгуй болгосон (Монгол улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, 2015).

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД		ОРОН НУТАГ
УРТ – 20 жил	МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ (15-20 жил)	
ДУНД– 4-10 жил	ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО (8-10 жил)	БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО АЙМАГ/НИЙСЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ
	ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР (4 жил)	АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, ДЭД ХӨТӨЛБӨР (4 жил)
	ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ (3 жил)	
	УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР (4 жил)	
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР (4 жил)		
БОГИНО- 1 жил	ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ	ОРОН НУТГИЙН ЖИЛИЙН ТӨСӨВ
	ТӨРӨӨС МӨНГӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

REDD+-ийн Стратеги/Үйл ажиллагааны төлөвлөгөөний хамгийн боломжтой хувилбарууд (Ой болон Уур Амьсгалын Өөрчлөлтийн Стратеги эсвэл хувирах Үйл Ажиллагааны Төлөвлөгөө)

6.1.1 Урт хугацааны бодлогын баримт бичгүүд

Тогтвортой үзэл баримтлал, экосистемийн үйлчилгээний төлбөр, тогтвортой ойн менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийн саарулах зэрэг асуудлын зарчмыг өндөр дээд хэмжээний хуулиудад тусгасан байдаг. Энэ баримт бичиг нь УИХ-ын түвшинд баталгааждаг учраас өндөр түвшний баримт бичиг юм. REDD+-ийн стратегийг энэ түвшинд боловсруулах боломжгүй.

Ой болон уур амьсгалын өөрчлөлтийн стратегийн (REDD+) үндсэн зарчмууд ийм өндөр түвшний үзэл баримтлалд аль хэдийн тусгалаа олсон бөгөөд энэ нь Ойн болон Уур Амьсгалын Өөрчлөлтийн (REDD+) стратегийн бичиг баримтуудыг эхлүүлэх чухал хэрэгсэл болж өгөх юм.

6.1.2 Дунд хугацааны бодлогын баримт бичгүүд

Энэ бичиг баримтууд нь 4-10 жилийн стратегийн зорилтыг тусгасан бөгөөд REDD+-ийн цаг хугацаатай тохирч байгаа. 6.2 т үүнийг тайлбарласан.

6.1.3 Богино хугацааны бодлогын баримт бичгүүд

REDD+-ийн болон ойн салбарын зорилтуудыг хангахад эдгээр баримт бичгүүд нь хэтэрхий товч. Гэхдээ дунд хугацааны бодлого болон мөнгөний бодлого хоёрын хоорондын уялдаа холбоо нь санхүүгийн нөөцийг хуваарилах үндсэн түлхүүр байж болох ба цаашид сайтар судлах шаардлагатай. Үүн дээр санхүүгийн нөөцийн хуваарилалтыг баталгаажуулахад чиглэлээр REDD+-ийн өргөтгөсөн ажлыг хэсэг ажиллах боломжтой юм.

Улсын төсвийн тухай хууль - Ирэх жилийн төсвийг хэлэлцэж баталдаг чухал баримт бичиг юм (жил бүрийн 11 сард хэлэлцдэг). REDD+-ийн өргөтгөсөн ажлыг хэсэг тухайн жилдээ шаардлагатай санхүүжилт хүрэлцээтэй эсэхийг хянаж, хуваарилалтыг баталгаажуулах. Зөвхөн нэг жилийн санхүүжилт учраас санхүүгийн найдваргүй байдал үүсгэх эрсдэлтэй.

6.2 Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хувилбаруудын дүн шинжилгээ

6.2.1 Төрийн бодлого

Төрөөс баримтлах шинэ бодлого - Энэ нь Парламентын түвшинд батлагддаг өндөр түвшний баримт бичиг юм. Ой болон Уур амьсгалын өөрчлөлтийн талаар хэрэгжиж буй бодлогууд бий бөгөөд Төрөөс баримтлах бодлогыг тохиромжтой хувилбар (Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Ногоон Хөгжлийн бодлого, Парисын гэрээ болон Ойн талаар төрөөс баримтлах бодлого) биш гэж үзсэн.

Зөвлөмж. Энэ нь REDD+-ийн стратеги/үйл ажиллагааны төлөвлөгөөнд тохиромжтой хувилбар биш. Парламентын түвшинд Монголд ой болон уур амьсгалын өөрчлөлтийн стратегийн бичиг баримтууд хангалттай тул Төрөөс REDD+-ийн талаар баримтлах бодлогыг батлуулах үндэслэл гаргаж ирэх бараг боломжгүй.

Ойн талаар төрөөс баримлах бодлогын төлөвлөгөөг шинэчлэх

Ойн талаар төрөөс баримлах бодлого нь 2015 онд батлагдсан. REDD+-ийн асуудлуудыг оруулж дахин шинэчлэх шаардлагатай гэсэн зөвлөмж бий.

Гэвч БОАЖЯ-ны техникийн мэргэжилтнүүд Ойн талаар төрөөс баримлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдаад удаагүй тул хангалттай үндэслэл болж чадахгүй гэж үздэг учраас энэ баримт бичгийг шинэчлэх сонирхол бага.

Нэмж хэлэхэд, энэ төрлийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахад өндөр түвшний дэмжлэг хэрэгтэй бөгөөд REDD+-ийн хэрэгжилтийн хугацаанд амжихгүй.

Зөвлөмж. Шинэчлэхэд хүндрэлтэй өндөр түвшний баримт бичиг юм.

6.2.2 Засгийн Газрын мөрийн хөтөлбөр

Энэ нь одоогийн Засгийн Газрын эрхийн хугацаанд хүчинтэй байх үйл ажиллагааны төлөвлөгөө бөгөөд эрх барьж буй намын зорилт болон одоогийн мөрдөж буй хуулиуд дээр үндэслэсэн.

Зөвлөмж:

Холбогдолтой биш ч REDD+-ийн стратегид Засгийн Газрын мөрийн хөтөлбөрийн зорилтыг багтаасан байх шаардлагатай.

6.2.3 Үндэсний хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Улсын хөгжлийн төлөвлөгөөнд зориулан хандивлагч нар, банк, засгийн газар болон хувийн хэвшлийнхэн дээр төвлөрсөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө юм.

Зөвлөмж:

Цаашид энэ төрлийн баримт бичгүүдийг сайтар судлах.

6.2.4 Үндэсний хөтөлбөр, түүний үйл ажиллагааны төлөвлөгөө

Үндэсний хөтөлбөр нь Монгол улсын хэмжээнд өргөн хүрээг хамарсан, чухал асуудлуудыг авч үздэг. Зөвхөн БОАЖЯ-ы хүрээнд ус, агаарын бохирдол, биологийн төрөл зүйл тусгай хамгаалалттай газар болон ногоон хэрэм гэх мэт салбарыг хамарсан үндэсний 17 хөтөлбөр хэрэгжиж байна. БОАЖЯ-ы холбогдох бодлогын мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтаар REDD+-ийн стратеги нь доорх бичиг баримтуудыг хэлбэртэй байх боломжтой гэсэн зөвлөмжийг өгсөн.

- Монгол улсын бодлого боловсруулалтын хуулийн дагуу REDD+н үндэсний стратеги нь биеэ даасан Үндэсний Хөтөлбөр эсвэл Дэд Үндэсний Хөтөлбөрийн (Үндэсний хөтөлбөрийн нэг бүлэг хэлбэрээр) хэлбэртэй байх боломжтой.
- Шинэ Үндэсний хөтөлбөр батлуулахын тулд үйл ажиллагаанууд нь бусад хөтөлбөрүүдтэй давхцаагүй, шинэлэг, сайтар бэлтгэсэн үндэслэлтэй байх шаардлагатай.
- Ойн болон уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь Ойн талаар төрөөс баримтлах бодлого болон Уур Амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрт аль хэдий нь багтсан байгаа бөгөөд Уур Амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчлэлд REDD+-ийг оруулах нь зүйтэй гэж мөн зөвлөсөн.

Зөвлөмж

Үндэсний хөтөлбөр нь Үндэсний стратегийн баримт бичигт (2-р бүлэг) хамгийн сайн тохирох хувилбар боловч одоогийн мөрдөж буй бодлогуудтай давхцах зэрэг, ялгаатай талыг харуулах шаардлага, мөн Яамны хүрээний ижил төрлийн маш олон баримт бичиг байгаа, загвар нь тохирохгүй зэрэг маш асуудлууд бий.

Үндэсний хөтөлбөрийн баримт бичгийг REDD+-ийн хүрээнд олон улсын доноруудын санхүүжилтийг татах үндсэн зорилготой боловсруулж, REDD+-ийн 4-н бүрэлдэхүүн хэсгүүдийг багтаасан байх шаардлагатай.

Үндэсний хөтөлбөрийн загвар нь REDD+-ийн стратеги, хөрөнгө оруулалтын баримт бичгийн загварт нийцэхгүй байгаа бөгөөд ерөнхий мэдээлэл бүхий, хийх ажлын жагсаалт хэлбэртэй. Баримт бичгийн тохирох загварын тал дээр БОАЖЯ-ы төлөөллүүдтэй хамтарсан уулзалт зохион байгуулах шаардлагатай. Энэ талын ажлууд дээр ажиллуулах зорилгоор өргөтгөсөн ажлын хэсгийг байгуулж шаардлагатай.

REDD+-ийг олон салбарын оролцогч талуудтай Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний Хөтөлбөр том хэмжээний баримт бичгийн нэг бүлэгт оруулж, нэгтгэхийг зөвлөхгүй.

6.2.5 Орон нутгийн хөгжлийн бодлого, түүний үйл ажиллагааны төлөвлөгөө, дэд хөтөлбөрүүд

Энэ нь аймгийн түвшний хөгжлийн төлөвлөгөө юм. Энэ салбар дундынх ба байгаль орчны салбар мөн багтана. Аймаг нь төрөл бүрийн татварын орлогоос санхүүждэг. Энэ чиглэлийн санхүүжилтийн механизм дээр зөвлөх баг ажиллана. Төлөвлөлтийг жил бүрийн 7 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл хийдэг.

Зөвлөмж: REDD+-ийн оролцоо, үйл ажиллагаа бүсийн болон орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой.

6.3 Стратегийн баримт бичиг - Үндэсний 'Стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө'

Зөвлөмж 1. Үндэсний түвшний биеэ даасан REDD+-ийн баримт бичгийг боловсруулах шаардлагатай, үүгээр өндөр түвшний дэмжлэгийг авч, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч, мөн REDD+-ийн 4-н бүрэлдэхүүн хэсгийг бүгдийг нь багтаах боломжоор хангагдана.

REDD+ баримт бичиг нь олон улсын санхүүгийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой бөгөөд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зарчим, хяналт тавих тогтолцоо болон хүлэмжийн хийг тайлагнах гэх мэт өргөн агуулгыг хамардаг тул бие даасан бодлогын хүрээнд авч үзнэ.

Зөвлөмж 2. Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөрийг шинэчилж (Үндэсний хөтөлбөрийн нэг бүлэг болгож) REDD+-ийн асуудлуудыг оруулж тусгах.

Зөвлөмж 3. Үндэсний хөтөлбөрийн баримт бичгийн загварыг REDD+-ийн стратегид тохирох загвар болгон шинэчлэх.

Үндэсний хөтөлбөрийн ихэнх баримт бичгүүдийн загвар REDD+-ийн шаардлагад нийцэхгүй байдаг. Эдгээр нь зөвхөн үйл ажиллагаа, асуудлуудын жагсаалт байдаг ба авч хэрэгжүүлэх арга хэмжээний тайлбар, тодорхойлолт, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацаа болон өөр бусад шаардлагатай мэдээллүүдийг багтаагаагүй байдаг. Тиймээс Үндэсний хөтөлбөрийн загварыг шинэчлэн ашиглах нь зүйтэй. Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөрийн загвар нь олон улсын зорилго, зорилт руу хандсан, харилцагч талуудыг оруулсан жишээ авахуйц сайн баримт бичиг болсон. Сайжруулсан загварын хувилбар санал болгож нэвтрүүлэхийн тулд Яамтай уулзалт зохион байгуулж хэлэлцэх шаардлагатай.

Зөвлөмж 4. Үндэсний хөтөлбөрт холбогдох салбаруудын дэмжлэг зайлшгүй шаардлагатай.

БОАЖЯ-ы харьяа Үндэсний хөтөлбөрүүд салбар дундын, олон талт оролцогч талуудын хамтын ажиллагааг шаарддаг. Жишээ нь: уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол гэх мэт.

6.4 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө – Үндэсний болон бус орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг зорилтууд, шалгуур үзүүлэлтүүд, төсөвтэйгөөр боловсруулна. Энэ чиглэлээр REDD+ стратегийг боловсруулахад шаардлагатай хоёр үндсэн асуудлыг тодорхойлох зайлшгүй хэрэгцээ байна. Үүнд:

- 1. Үндэсний, эсвэл бус нутгийн гэдгийг тодорхойлох**– Хэдийгээр Үндэсний стратегийн баримт бичиг нь Үндэсний түвшинд байхаар боловч 3-4 үндсэн аймгуудыг багтаасан бүс нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг мөн үүнд багтаан ойлгож болно. Түүнчлэн бореал болон заган ойн бүсээр нь ялган оруулах боломжтой. Үүнээс харахад зөвхөн заган ойтой холбоотой төлөвлөгөө боловсруулж хөрөнгө оруулалтыг татах нөхцөл боломж байна.
- 2. Монгол улсын нөхцөлд тохирсон бодлогын баримт бичиг** – Монгол улсад ямар бодлогын баримт бичиг тохиромжтой бэ? .

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах загвар нь хэд хэдэн шалгуур үзүүлэлттэй байх ба хавсралтад нэмэлт мэдээллүүдийг багтаасан. Энэхүү загвар нь ерөнхий төсөл боловсруулалт болон төлөвлөлтийн загвараас эх авсан, хөрөнгө оруулалтын форматтай ижил байж болно. 3.0-р хавсралтад Сангийн яамны танилцуулга, зөвлөмжөөс татаж авсан загварыг харуулсан.

Зөвлөмж. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн дагуу Үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар нь Хавсралт 1, 2, 5 ба 6-ын дагуу байж болно (энэ баримт бичгийн Хавсралт 4.0-т заасан болно.).

7.0 Дараагийн алхмууд

Яамны өндөр түвшний шийдвэр гаргагчдын уулзалтыг зохион байгуулах - Үндэсний хөтөлбөр байх эсэх эсвэл ямар төрлийн бичиг баримт боловсруулах талаар шийдвэр гаргах түвшний уулзалтыг яаралтай зохион байгуулах, ингэснээр дараагийн авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тодорхой болох юм.

Үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг байгуулах - Шаардлагатай баримт бичгийг боловсруулах түр хугацааны ажлын хэсгийг байгуулах.

Ажлын хэсгийн төлөвлөгөөний урьдчилсан төсөл - Бодлогын баримт бичиг боловсруулах ажлын төлөвлөгөөг оролцогч талуудтай боловсруулж, батлах.

Шаардлагатай техникийн баримт бичгүүд: Үндэсний хөтөлбөрийг боловсруулахад эхний ээлжид доорх 2 техникийн баримтууд шаардлагатай:

- Нөхцөл байдлын дүн шинжилгээ
- Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

Үндэсний хөтөлбөр боловсруулах зөвшөөрөл авсан нөхцөлд ямар бичиг баримтууд шаардлагатай, хэрхэн зохион байгуулах, ажлын хэсэг байгуулах тал дээр О.Билгүүн ажиллана.

Хавсралт 1.0 Хэлэлцэх шаардлагатай REDD+-ийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийн хууль эрх зүйн нөхцөл байдал

1. **Үндэсний ойн мониторингийн систем** - тус системийг ямар хэлбэрээр ажиллуулах талаарх судалгаа хийгдэж байгаа ба байгууллагуудын оролцоо, хууль эрх зүйн ямар хэлбэрээр байх ёстойг удахгүй тодорхойлно. Ойд хяналт, мониторинг хийх талаарх хууль эрх зүйн баталгаажуулалт, мөрдөх хууль, журам шаардлагатай эсэх нь тодорхойгүй байна. Ойрын үед тодорхой болгох шаардлагатай.
2. **Ойн суурь түвшин** - энэ чиглэлээр холбогдох ажлууд хийгдэж байгаа ба ойрын хугацаанд хариуцах байгууллагын зохион байгуулалт буюу ямар байгууллага хариуцах, мөн хууль эрх зүйн нөхцөлийг тодорхой болгох шаардлагатай.
3. **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн систем** - энэ мэдээллийн систем хэрхэн ажиллах талаарх судалгаа хийгдэж байгаа ба ойрын хугацаанд хариуцах байгууллагын зохион байгуулалт буюу ямар байгууллага хариуцах, мөн хууль эрх зүйн нөхцөлийг тодорхой болгох шаардлагатай. Сөрөг нөлөөллөөс сэргийлэн хамгаалах талаарх хуулийн шийдвэр, баталгаажуулалт, мөрдөх хууль дүрэм зэрэг нь мөн ойрын үед тодорхой болно.
4. **Хөрөнгө болон Санхүүжилт** – санхүүжилтийн асуудлууд дээр тусгайлсан судалгааг хийх ба Сангийн яамны эсвэл доноруудын шаардлага, журмын дагуу зохицуулагдах төлөвтэй байна. Үр дүнд суурилсан урамшууллыг хүртэх магадлал бага учраас зарим орнуудын адилаар Монгол улсад REDD+-ийн санг байгуулах магадлал мөн бага юм. Гэхдээ Монгол улс дасан зохицох, Биологийн олон янз байдал болон ойн тогтвортой менежментийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг татах бүрэн боломжтой. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс ихээхэн хэмжээний орлого орж ирдэг ба ойгоос орсон орлогын 75% -ийг эргүүлээд байгаль хамгаалахад зарцуулах хуультай ч тухайн сум орон нутаг орлогын багахан тодорхой хувийг л байгаль хамгаалах үйл ажиллагаандаа зарцуулдаг.



Хавсралт 2.0 Ашигласан ном хэвлэлийн жагсаалт

<https://www.dropbox.com/sh/o6d3i6owlej91ts/AAC2guFRy4p-A9T6WqBo8DSBa?dl=0>

Дээрх холбоосоор дараах баримт бичгүүдийг харах боломжтой:

Вьетнамын REDD+-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө – Тухайн улсын мөрдөгдөж буй бодлогын хүрээнд хийгдсэн товч баримт бичгийн жишээ.

Вьетнам улс мөн орон нутгийн түвшинд 6 бүс нутгийг хамарсан REDD+-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө Нүүрстөрөгчийн санд зориулан боловсруулагдсан байдаг.

Мьянмарын REDD+-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө – Одоогоор боловсруулах шатанд байгаа бөгөөд маш дэлгэрэнгүй, нарийвчилсан баримт бичиг.

Папаяа Шинэ Гвиней улсын үйл ажиллагааны төлөвлөгөө – бүс нутгийн REDD+-ийн ажлын албаны зөвлөж буй бодлогын баримт бичгийн хувилбар, товчхон (30 орчим хуудас) бодлогын баримт бичиг. Дагалдах дэлгэрэнгүй хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулах боломжтой.

Монгол улсын REDD+-д бэлтгэх төлөвлөгөө – Энэхүү баримт бичиг нь Байгаль орчны яамны түвшинд батлагдсан, агуулга болон загварын хувьд Папаяа Шинэ Гвиней улсын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ижил төрлийн баримт бичиг юм.

Монгол улсын Үндэсний Хөтөлбөр – Байгаль орчны яамны Үндэсний 17 хөтөлбөр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд REDD+-ийн стратегийн баримт бичиг нь эдгээр хөтөлбөрүүдтэй давхцахгүй байх шаардлагатай. Үндэсний хөтөлбөрүүдтэй танилцаж байхад, жишээ нь цөлжилт агаарын бохирдол болон ногоон хэрэм зэрэг жишээнээс харахад суурь мэдээлэл бүхий ерөнхий үйл ажиллагааны жагсаалт хэлбэртэй байна.

- Энэ баримт бичгийн загвар нь Монгол улсын REDD+-ийн бодлогын баримт бичигт загварт нийцэхгүй.

Одоогийн байдлаар Уур амьсгалын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчилж байгаа бөгөөд REDD+-ийн асуудлуудыг тус баримт бичигт тусгах боломж байгаа юм. Гэхдээ үйл ажиллагааг нарийвчилсан байдлаар тусгах зорилгоор Монгол улсад REDD+-ийн бие даасан бодлогын баримт бичгийг боловсруулахыг зөвлөмж болгож байна. Ингэснээр бүх салбарын мэдээллийг хамруулсан уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний хөтөлбөр гэх мэт хэт том хэмжээний баримт бичигт REDD+-ийн үйл ажиллагаанууд уусах биш, УИХ болон Яамны түвшинд баталгаажуулсан Үндэсний биеэ даасан баримт бичгийг боловсруулах нь давхар олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг баттайгаар татах боломжийг бий болгоно.

Биологийн олон янз байдлын Үндэсний хөтөлбөр нь бусад хөтөлбөрүүдээс өөр загвараар боловсруулагдсан бөгөөд REDD+-ийн стратегийн баримт бичгийн загварт нийцнэ.

Хавсралт 3.0 Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн дагуу Үндэсний хөтөлбөр боловсруулахад шаардлагатай зарим хавсралтууд

Хавсралт 1: хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн зорилго, зорилтын уялдаа

№	Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	Төрөөс баримтлах бодлого	Бүсчилсэн хөгжлийн бодлого (Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал)	Бусад бодлогын баримт бичиг
		Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт
1					
2					
3					
4					
...					
Нийт					
Нийцсэн* (тоо, %)					

Тайлбар танилцуулга:
(Энэ хэсэгт хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь бусад бодлогын зорилго, зорилттой хэрхэн уялдаж байгаа талаар товч танилцуулга бичнэ)

Хавсралт 6: Үйл ажиллагааны төлөвлөгөө

Зорилго		Бодлого, хөтөлбөрийн зорилго				
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан үр нөлөөг бичнэ. Түүнчлэн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд ашиглах үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг бичнэ.				
1. Үйл ажиллагааны чиглэл		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1						
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 2						
2. Үйл ажиллагааны чиглэл		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1						



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



<http://www.reddplus.mn>



REDD+ in Mongolia



REDD+ in Mongolia



REDD+ in Mongolia

UN-REDD
PROGRAMME



Food and Agriculture
Organization of the
United Nations



Empowering lives.
Restoring nature.

The UN-REDD Programme / Mongolia

*Address: Government Building II, United Nations Street
5/2, Chingeltei District, Ulaanbaatar 15160, Mongolia*

Tel: +976-7711-7750

Email: info@unredd.mn

Web site: www.reddplus.mn